**РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ**
**УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН**
**ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 19 өдөр Дугаар А/118 Улаанбаатар хот

Үр дүнгийн нэмэгдэл олгох журам
батлах тухай

“Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.3.10 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын ажлын үр дүнг нь тухайн сар тутамд нь үнэлж, үр дүнгийн нэмэгдэл олгосугай.

2. “Үр дүнгийн нэмэгдэл олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Удирдах ажилтны ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар, 5 аймгийн болон 3 салбарын дарга нарын ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар, Албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

3. Албан хаагчдын үр дүнг журмын дагуу тооцож олгохыг Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Б.Батмөнх/, Хөвсгөл, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь аймгуудын Радио телевизийн сүлжээний газрын дарга /Г.Пунцагбалжир, Н.Дидар, Б.Ариунтуяа, О.Намуунзул, Б.Цогтсайхан/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Тушаалын биелэлтийг хангаж ажиллахыг тус газрын төв болон орон нутаг дахь газар, салбар, нэгжийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Л.Ууганцэцэг/-д тус тус даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан “РТҮС” УТҮГ-ын захирлын 2016 оны “64 дүгээр тушаалын арван хоёрдугаар хавсралтын 7”-г хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ С.ЦАГААНХҮҮ

0000035

“Радио телевизийн үндэсний сүлжээ”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын
2021 оны ...А/18... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

# АЛБАН ХААГЧДАД ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журам нь албан хаагчдын ажлын чанар, үр дүнг бодитой үнэлж, идэвх санаачлагыг дээшлүүлэхэд оршино.

1.2 Тус газрын орон нутаг дахь газар, салбар, хэлтэс, албаны нийт албан хаагчдад ажлын үр дүнг үнэлж, нэмэгдэл олгоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

## ХОЁР. АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

2.1 Үүрэгт ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, тухайн сардаа үр бүтээлтэй ажилласан албан хаагчид үр дүнгийн нэмэгдэл олгоно.

2.2 Сар бүрийн ажлын тайлангаа дараа сарын 5-ны өдрийн дотор газар, салбар, хэлтэс, албаны даргадаа танилцуулж, дүгнүүлснээр ажлын үр дүнгийн нэмэгдэл сар бүрийн 15-ны өдрийн цалин дээр олгогдоно.

2.3 Туршилтын хугацаа нь дуусаагүй эсвэл хөлсөөр ажиллах гэрээ болон, төсөвт байгууллагын ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа ажилтанд үр дүнгийн нэмэгдэл олгохгүй.

2.4 Сар бүрийн үр дүнгийн нэмэгдэл нь ажилтны тухайн сарын бодогдсон цалингийн 10 /арав/ хүртэл хувь байна.

2.5 Үр дүнгийн нэмэгдлийг тухайн албан хаагчийн ажлын цаг ашиглалт/хоцролт, таслалт/, ажлын ачаалал, үүрэг даалгаврын биелэлт, шинэ санал, санаачилга, ажлын тайлан болон хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ. Дүгнэхдээ тухайн шалгуур үзүүлэлтэд заасан ажлыг хангалттай гүйцэтгэсэн гэж үзсэн тохиолдолд оноог бүрэн олгох, дутуу гүйцэтгэлтэй гэж үзвэл оноог гүйцэтгэлээс хамаарч хувилж тооцох, хангалтгүй гэж үзвэл 0 оноогоор дүгнэх хэлбэрээр үнэлнэ.

2.6 Албан хаагчдын ажлын үр дүнг газар, салбар, хэлтэс, албаны дарга шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, цалингийн цагийн тодорхойлолтын хамт холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

2.7 Тус газрын дэд захирал, хэлтэс, албаны даргын ажлын үр дүнг газрын захирал дүгнэх бөгөөд газрын захирлын эзгүйд дэд захирал дүгнэнэ.

2.8 Орон нутаг дахь газар болон хот орчмын салбарын дарга нарын үр дүнг Захиргааны удирдлагын хэлтэс, Техникийн хэлтэс, Шуурхай удирдлагын хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга нар тус бүрийн

хариуцсан чиглэлийн дагуу /хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлт/ дүгнэх бөгөөд түүнийг нь газрын захирал батална.

## ГУРАВ. БУСАД

3.1 Үр дүнгийн нэмэгдлийг дараах тохиолдолд олгохгүй. Үүнд:

3.1.1 Тухайн сарын ажилласан цаг нь 70 хувиас доош бол;

3.1.2 Тухай сард ээлжийн амралттай /өвчтэй, чөлөөтэй/ бол;

3.2 Үр дүнг бодитой бус дүгнэсэн тохиолдолд Захиргааны удирдлагын хэлтсийн дарга хянаж, дахин үнэлэх эрхтэй.

---o0o---

“Радио телевизийн үндэсний сүлжээ”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын
2021 оны A/18 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

# УДИРДАХ АЖИЛТНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ | ОНОО | ДЭД ЗАХИРАЛ /ТӨВИЙН БҮС/ | ДЭД ЗАХИРАЛ /ОРОН НУТАГ/ | ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС | САНХҮҮГИЙН ХЭЛТЭС | ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС | ТЕХНИКИЙН ХЭЛТЭС | ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС | МАРКЕТИНГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС | ХАНГАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгууллагын дүрэм, дотоод журам, ХАБЭА зөрчил, гологдол саатал гаргасан эсэх | 1 | | | | | | | | | |
| 2 | Тухайн сарын ажлын цаг ашиглалт /хоцролт, өвчтэй, чөлөөтэй, таслалт, захирлын зөвлөлийн хурал, шуурхай хурал, өглөөний шуурхай хурлын ирцийг харгалзана/ | 1 | | | | | | | | | |
| 3 | Өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, цаг хугацаандаа өгсөн эсэх /захирлын болон захиргааны зүгээс өгсөн үүрэг/ | 1 | | | | | | | | | |
| 4 | Тухайн сарын төлөвлөгөөт ажлын биелэлт, тайлан мэдээг цаг хугацаанд нь өгсөн эсэх /тайлан, төлөвлөгөө, мэдээ, судалгаа, шилэн данс, худалдан авалтын тайлан, егр ашиглалт, дотоод хяналт шалгалт/ | 2 | | | | | | | | | |
| 4 | Цаг үеийн шинж чанартай ажлын оролцоо /сургалт, семинар, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал, уралдаан, томилолт, тэмцээн/ | 1 | | | | | | | | | |
| 5 | Хариуцсан газар, салбарын уялдаа, хамтын ажиллагаа /тайлан, цаг үеийн мэдээ мэдээлэл, бусад заавар зөвлөгөө өгч ажиллаж байгаа байдал/ | 1 | | | | | | | | | |
| 6 | Шинэ санаачлага гаргаж, бусдаас илүү идэвх үр дүнтэй ажилласан байдал | 3 | | | | | | | | | |
| | **НИЙТ ОНОО** | **10** | | | | | | | | | |

ДҮГНЭСЭН: ЗАХИРАЛ

“Радио телевизийн үндэсний сүлжээ”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын
2021 оны А/12 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

БАТЛАВ
“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ С.ЦАГААНХҮҮ

202.. оны ... сарын ... өдөр

## ОРОН НУТАГ ДАХЬ ГАЗАР БОЛОН 3 САЛБАРЫН ДАРГА НАРЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| ДҮГНЭХ ХЭЛТСИЙН НЭР | ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ | ХӨВСГӨЛ АЙМГИЙН РТСГ | БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН РТСГ | ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН РТСГ | ӨМНӨГОВЬ АЙМГИЙН РТСГ | ДОРНОД АЙМГИЙН РТСГ | ТЕЛЕВИЗИЙН ТӨВ СТАНЦ | ХОТЫН ШУГАМЫН РАДИОГИЙН АЛБА | РАДИО НЭВТРҮҮЛЭХ ТӨВ СТАНЦ | ХЭМЖИЛТ, ЗАСВАРЫН ТӨВ | ОНОО | ДҮГНЭСЭН АЛБАН ТУШААЛТЫН ГАРЫН ҮСЭГ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТЕХНИКИЙН ХЭЛТЭС | Чанарын үзүүлэлт /тусгайлан дүгнэх хүснэгтийн дагуу/ | | | | | | | | | | 3 | |
| ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС | Мэдээ өгөлт, шуурхай ажиллагаа | | | | | | | | | | 1 | |
| САНХҮҮГИЙН ХЭЛТЭС | Тайлан мэдээ гаргалтын чанар, ирүүлэлт /Санхүү, хөрөнгө оруулалттай холбоотой бүх төрлийн мэдээ, тайлан, судалгаа, шилэн данс, худалдан авалтын тайлан/ | | | | | | | | | | 1 | |
| ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС | ХАБ ЭА, ГАУС ажлын биелэлт, үзлэг шалгалт хийж сайжруулсан, урьдчилан сэргийлсэн, зааварчилгаа өгөх, мөрдөх, зөрчлийг арилгахаар авсан арга хэмжээ, Дотоод хяналт шалгалтын журам, аргачлалын дагуу хийж гүйцэтгэж байгаа ажил | | | | | | | | | | 1 | |
| ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС | Тухайн сарын төлөвлөгөөт ажлын биелэлт, тайлан мэдээг цаг хугацаанд нь өгсөн эсэх /тайлан, төлөвлөгөө, мэдээ, судалгаа, егр ашиглалт/ | | | | | | | | | | 1 | |
| | Шинэ санаачлага гаргаж, бусдаас илүү идэвх үр дүнтэй ажилласан байдал | | | | | | | | | | 3 | |
| НИЙТ ОНОО | | | | | | | | | | | 10 | |

Радио телевизийн үндэсний сүлжээ”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын
2021 оны А/118 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

# АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | НЭР | АЛБАН ТУШААЛ | ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ | | | | | | НИЙТ ОНОО |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Байгууллагын дотоод дүрэм, журмын хэрэгжилтийг бүрэн хангасан, ХАБЭА зөрчил гаргасан эсэх | Ажлын байрны тодорхойлолт, үндсэн ажил үүргийн хуваарийн дагуу 7 хоног, сар, улирлын төлөвлөгөөт ажлын тайлан, мэдээг цаг хугацаанд нь өгсөн эсэх | Ажлын цаг ашиглалт /хоцролт, таслалт, өвчтэй, чөлөөтэй/ | Цаг үеийн онцгой, яаралтай өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн эсэх | Байгууллагаас болон тухайн нэгжээс зохион байгуулсан нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхтэй оролцсон эсэх | Шинэ санаачлага гаргаж, бусдаас илүү идэвх үр дүнтэй ажилласан байдал | |
| | | | 1 /хүртэл/ | 2 /хүртэл/ | 1 /хүртэл/ | 2 /хүртэл/ | 1 /хүртэл/ | 3 /хүртэл/ | 10 /хүртэл/ |
| | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | |

ДҮГНЭСЭН: ХЭЛТЭС/АЛБА ДАРГА